



www.dardas.mn
facebook.com/dardas.mn
twitter.com/MMdardas
mongolinmedeesonin@gmail.com

- “Дэлхийн сонины холбоо”-ны гишүүн
- 1999 оны шилдэг чөлөөт хэвлэл
- 2002 оны шилдэг хэвлэл
- 2013 оны Монгол Улсын шилдэг сонин
- Best of Mongolia-2016 - Оны шилдэг сонин



20 дахь жилдээ

Дугаарыг эрхэлсэн Батбуянгийн ПҮРЭВЖАВ

ДЭЛХИЙН ХҮН

“СЕРИАЛ ОД” ЭРКАН ПЕТЕККАЯА



Б.ДАВААХҮҮ
Davaakhuu0128@gmail.com

Дэлхийн 80 гаруй орны дэлгэцнээ гарсан Туркийн “Аз жафгалын хэлтэрхий” цуврал кино эдүгээ ч манай үзэгчдийг байлдан дагуулсан хэвээр байгаа билээ. Тэгвэл тус кинонд Жихан Гюрпнар буюу хүчирхэг бизнесмэн, ухаалаг эцгийн дүрийг бүтээсэн жүжигчин Эركان Петеккаяаг “Дэлхийн хүн” буландаа онцолж байна.

Үргэлжлэл нь
VII нүүрт

ДОТОР НҮҮРТ

IV НҮҮРТ:

ЕРӨНХИЙ
САЙД АСАН
Ч.САЙХАНБИЛЭГ,
С.БАЯР НАРЫГ
ҮРГЭЛЖЛҮҮЛЭН
ХОРИХООР
БОЛОВ

...“Засгийн газрын шийдвэрийг буруу гэж үзэх юм бол Засгийн газар өөрөө эсвэл УИХ хэлэлцэж хүчингүй болгоно гэсэн заалт бий. Гэтэл тов тодорхой зохицуулалттай зүйлийг хууль хяналтын байгууллага хэлэлцэж байна. Цаашдаа мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилнэ” хэмээлээ...

ҮЗЭЛ БОДОЛ

МАН, МАХН-ын хоёр,
АН-ын зургаан улстөрч

ХЭЦҮҮ НЭРТЭД ХОРИГДЖЭЭ



Б.ӨНӨРТӨГТОХ
baljirunurtogtokh@gmail.com

Ардчилсан Монгол Улсад юу хүссэнээ хийж, төрд тухалсан зөөлөн суудлаа буруугаар ашиглаж байсан олон албан тушаалтнууд шоронд хоригдож, зарим нь наранд шалгуулж байна. Нам ялсан үед тэд хуулиас дээгүүр мэт аашилж, юу хүссэнээ хийдэг. Харин нам ялагдсаны дараа оймстой, оймсгүй ачуулж, хорих ангиас “хайрын захидал” илгээн буруугүй мэтээр өөрсдийгөө зарлах нь олон. Ерөөс улс төрийн аль нам эрх барьж буйгаас шалтгаалж хоригдох улстөрчид нь хүртэл намаараа ялгарна. Ойрын үеийн жишээнээс харвал Ардчилсан нам ялсан үед МАН-ын нэр бүхий улстөрчдийг шалгаж, цагдаж, бүр ял хүртэл өгч байлаа. Харин МАН ялсан энэ цагт АН-ын гэх тодотголтой хэд хэдэн улстөрч өргөст торны цаана бүтэн сар, зарим нь 14 хоног хоригдоод гарч ирэв.

Үргэлжлэл нь III нүүрт

GOO.N
6/16-г дуустал
ЖИВХ БҮР БЭЛЭГТЭЙ
АМЬСГАЛДАГ ЖИВХ
7575-5550
GOO.N Mongolia Албан
ёсны дистрибьютер

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Улаан номонд орсон загас Балжийн голоос олджээ

Г.САНЖААХАНД

Онон-Балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагчид энэ сарын 1-8-нд тус газрынхаа “А” хэсэгт судалгаа, эргүүл, хяналт шалгалтаар ажиллажээ. Энэ үед Хэнтий аймгийн Дадал сумын нутаг Балжийн голын Тавтын гацаа нэртэй газарт Монгол Улсын Улаан номын ховор ангилалд орсон Зантахай загасыг бүртгэсэн байна. Тус загасны биеийн урт нь 23 см байсан гэнэ. Мөн энэхүү загас нь 2013 онд тус голын эрэгт үхсэн байсныг нь олж байжээ. Зантахай загас нь Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан дансанд “Мэдээлэл дутмаг” гэсэн зүйлд хамаардаг ажээ. Учир нь тархацын хувьд маш сийрэг бөгөөд Амар мөрний сав, Сахалин, Онон гол зэрэг цөөхөн газар байдаг юм байна. 1930 онд Хэнтий аймгийн Биндэр сум орчмын Онон голоос баригдсанаар Монгол Улсад анх бүртгэгдэж байжээ

Тагтан дээрээ шатах материал тавихгүй байхыг анхааруулж байна

Г.САНЖААХАНД

Сүүлийн үед орон сууцанд гал гарах асуудал ихэсчээ. Хоёр хоногийн өмнө Замын цагдаагийн газрын зүүн талын орон сууцанд гал гарч айлын тагт шатсан хэрэг гарсан. Гал юунаас гарсан талаар онцгой байдлын албанаас тодруулахад, “Тагтан дээрээ амархан шатах эд зүйлс хурааж тавьснаас болж гал гарсан байгаа юм. Одоогоор галын дүгнэлт эцэслэж гараагүй” гэсэн хариулт өглөө. Иймээс орон сууцанд амьдардаг айл өрхийг анхаарал сэрэмжтэй байх, мөн галын аюулгүй байдлаа сайн хангах, ахуйн газтай болгоомжтой харьцах, ил гал түлж, шүдэнз асааж зурахгүй байхыг анхааруулж байна.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

КИЛ КАН МУТ: 15 НЭР ТӨРЛИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХУУРАМЧААР ҮЙЛДЭЖ БАЙНА



Г.САНЖААХАНД
xandaa1995@gmail.com

Сүүлийн үед иргэд БНСУ-ын виз мэдүүлэхдээ бүрдүүлэн өгдөг бичиг баримтаа хуурамчаар үйлдэх тохиолдол ихэсч байгаа аж. Энэ талаар БНСУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны консул Кил Кан Мугаас тодрууллаа.

-БНСУ руу зорчихоор виз мэдүүлж буй иргэд бичиг баримтыг хуурамчаар үйлдэх тохиолдол ихэсч байна гэсэн. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

-Сүүлийн үед БНСУ-д зорчих виз мэдүүлэхдээ хувийн хэвшлийн болон төрийн байгууллагын бичиг баримтыг хуурамчаар үйлдэх асуудал их гарах болсон. Өнөөгийн байдлаар Солонгос улсад Монгол Улсын нийт хүн амын нэг хувьтай тэнцэх буюу 30 мянга орчим иргэд оршин сууж байгаагийн таван мянга гаруй нь оюутан сурагч байдаг. Мөн Солонгост сурч, хөдөлмөрлөх зорилгоор түр оршин суугаад буцсан 300 мянга гаруй иргэд бий. Хоёр улс хооронд харилцан зорчих иргэдийн тоо жилд 150 мянга орчим байдаг бөгөөд БНСУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-нд өдөрт 900 орчим иргэн манай улс руу зорчих хүсэлтээ илэрхийлж виз мэдүүлдэг. Иргэдийн зорчих урсгал нэмэгдэж, тус улсыг зорих сонирхолд дөрөөлөн зарим нэг хууль бус үйлдэл гарч байна. Тухайлбал, БНСУ руу зорчихоор виз мэдүүлж буй иргэдийн эдийн засаг, санхүүгийн

баталгааг лавлах зорилгоор Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг бүрдүүлэх материалын жагсаалтад оруулсан. Гэвч иргэд тус лавлагааг хуурамчаар үйлдэх тохиолдол буурахгүй байгаа тул Нийгмийн даатгалын байгууллага болон манай улсын ЭСЯ хамтран ажиллаж, хяналт тавихаар болсон.

-Иргэд ямар бичиг баримтыг хуурамчаар үйлдэж байна вэ?

-Иргэдийн виз хуурамчаар мэдүүлж байгаа бичиг баримтуудын төрлийг авч үзвэл төрийн байгууллагуудын олгож байгаа бичиг баримтнаас нийгмийн даатгалын болон гэрлэлтийн лавлагаа, банкны таван сая төгрөг байршуулсан гэрээ, ТЕГ-аас олгож байгаа хуулийн этгээдийн удирдлагын овог, нэрийг сольсон тодорхойлолт байсан. Мөн өөрийгөө оюутан сурч байгаа нь үнэн гэсэн оюутны үнэмлэх, төлбөр төлсөн баримт, дүнгийн хуулбар, ажлын газрын тодорхойлолт, урилга, дансны хуулга, Европын болон гадны орнууд руу зорчсон штампыг хуурамчаар үйлдсэн тохиолдол олноор гарсан. Энэ мэт 15 нэр төрлийн

...Хуурамч бичиг баримтаар виз мэдүүлсэн тохиолдолд 1-5 жил хүртэлх хугацаагаар зорчих эрхийг нь хязгаарлаж, хуурамч бичиг баримт үйлдэж өгсөн хүний БНСУ руу зорчих эрхийг хугацаагүйгээр хязгаарлан виз олгохоос түтгэлзүүлэх арга хэмжээ авна...

бичиг баримтыг хуурамчаар үйлдэж байна.

-Бичиг баримт хуурамчаар үйлдсэн этгээдүүдэд ямар хариуцлага тооцох вэ?

-Хуурамч бичиг баримтаар виз мэдүүлсэн тохиолдолд 1-5 жил хүртэлх хугацаагаар зорчих эрхийг нь хязгаарлаж, хуурамч бичиг баримт үйлдэж өгсөн хүний БНСУ руу зорчих эрхийг хугацаагүйгээр хязгаарлан виз олгохоос түдгэлзүүлэх арга хэмжээ авна. Мөн хуурамч бичиг баримт үйлдэх, мэдүүлэх нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл

тул зөвхөн тухайн улс руу зорих эрхийг түдгэлзүүлээд зогсохгүй Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу хууль хяналтын байгууллага арга хэмжээ авдаг. Иймд энэ мэт хууль бус үйл ажиллагаанд оролцож хохирогүй байхыг иргэдэд анхааруулж байна.

-Хуурамч бичиг баримт бүрдүүлдэг хүмүүсээс болж иргэд дунджаар хэдэн төгрөгөөрөө хохирч байгаа вэ. БНСУ-ын виз хүлээн авдаг хэдэн байгууллага байдаг вэ?

-Хууль бусаар бичиг баримт үйлдэж өгдөг этгээдүүд цахим сүлжээгээр дамжуулаад өөрсдийгөө сурталчилдаг. Энэ хүмүүс ойролцоогоор 100 мянгаас таван сая хүртэлх төгрөгөөр хууль бус бичиг баримт үйлдэж өгдөг нь тогтоогдсон. Тиймээс энгийн иргэд хамгийн ихээр хохирч байгаа нь асуудал болоод байна. Яагаад гэвэл БНСУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ нь Консулын үйл ажиллагаа явуулах явцад ялангуяа визтэй холбоотой ямар ч мөнгө төгрөг, эд хөрөнгийн зүйл авдаггүй. Тиймээс ЭСЯ-нд таньдаг хүн байгаа виз гаргаж өгнө гэсэн асуудал ярьж байгаа бол ташаа мэдээлэл. Ийм зүйл байдаггүй. Тиймээс манай ЭСЯ-ны зүгээс албан ёсоор визийн төлөөлөн гүйцэтгэх найман газрыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулаад хамтран ажилладаг. Хэрвээ виз мэдүүлэхийг хүсч байгаа бол эдгээр байгууллагууд иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлж байгаа. Тиймээс ямар нэгэн ойлгомжгүй зүйл байвал эдгээр найман байгууллагад хандах хэрэгтэй.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

“Бүх нийтээр мод тарих өдөр” маргааш болно

Х.БОЛОРТЭНГИС

Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гарагийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” хэмээн зарласан билээ. Тэгвэл энэ жилийн “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” маргааш тохнож байна. Энэ өдөр жил бүр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарьдаг байсан бол энэ жил “Монгол наадам” цогцолбор болон цэвэрлэх лагийн талбайд УСҮГ-ын зохион байгуулалттайгаар мод тарих юм байна. Мод тарьж буй бүх газарт үзэсгэлэн худалдаа давхар зохион байгуулагдах ажээ.

Шингэрүүлсэн хий худалдаалдаг газруудыг шалгаж эхэллээ

Х.БОЛОРТЭНГИС

НЦГ-ын Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, НОБГ, НМХГ, Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын хамтарсан шалгалт хийж байна. Хүүхдүүд ахуйн хэрэглээний шингэрүүлсэн шатдаг хий /газ/ үнэрлэн амь нас, эрүүл мэндээрээ хохирохоос урьдчилан сэргийлэх, сургуулийн сурагч, өсвөр насны хүүхдэд шингэрүүлсэн шатдаг хийн хор уршгийг сурталчлан таниулах зорилготой аж. Тиймээс шатдаг хий болон шингэрүүлсэн хий худалддаг томоохон худалдааны төв, зах, хүнс, барааны бөөний худалдааны төв, супер маркет, минн маркет, хүнсний дэлгүүр, түргэн үйлчилгээний цэгүүдэд хамтарсан үзлэг шалгалт явуулж байгаа юм байна.

ЗАР

-ХҮД, 120 мянгатад хуучны гал тогоо тусдаа 3 өрөө байр яаралтай зарна. Үнэ 110 саяас. **Утас 99145060**
-Хуучин дамбын эцэст хөл хөдөлгөөн ихтэй үйлчилгээний 2 давхар 252 м2 объект 600 м2 газрын хамт худалдана. Үнэ 360 саяас. Жич: бүх чиглэлээр ашиглах боломжтой, бартер оролцуулах боломжтой. /Сарын түрээсийн орлого 4 сая/ **Утас 99145060**
-Bella Vista-д тансаг зэрэглэлийн 244 м2 Дутлекс орон сууц түрээслүүлнэ. Жич: тавилгатай, урсгал зардал үнэд багтсан. /Сарын түрээс 7 сая/ **Утас 99145060**
-Залуус хороололд 20.5 м2 1 өрөө байр хямд худалдана. /Үнэ 31 саяас/ **Утас 99145060**
-Да Хүрээ-гийн зүүн талд 36м2 2 өрөө байр маш хямд худалдана. /Үнэ 41 саяас/ **Утас 99145060**
-10 хороололд цэлгэр, саруулхан, том зайтай 64.5 м2 2 өрөө байр зарна. /М2 үнэ сая 450/ **Утас 99145060**
-Талбайн баруун талд ТЕГ 50-р байранд хуучны 53 м2 одоогоор 80 м2 3 өрөө байр зарна. Үнэ 264 саяас. **Утас 99145060**

PHOTO NEWS



Өчигдөр Нийслэлийн тээврийн газар болон Нийслэлийн төв захиргааны байр “Хангарьд” ордны урд микро автобусны жолооч нар жагслаа.

ХӨЛСНИЙ АМТ

УДАМ ДАМЖСАН ФЕРМЕР



Х.БОЛОРТЭНГИС
bolorkhand0726@gmail.com

Жирийгэл эгнэсэн хар тарлан үнээн дунд энэ тэрийг хийн, чөлөө завгүй хөдлөх нуруулаг хүдэр эрийг Болдбаа-

тарын Баяржаргал гэдэг. Тэрбээр энэ фермийн эзэн, даруухан яриатай, намуухан дуутай залуухан бизнесмен. Бизнесмен гэхээсээ илүүтэй эгэл малчин ард гэвэл түүнд илүү зохиомор санагдана. Фермийн дунд төрж өссөн тэрбээр хот хүрээ бараадаж, сургууль номын мөр хөөхөөс илүүтэй ижил дасал болсон

фермдээ үлдэж, аавынхаа ажлыг өвлөхийг сонгосон нь энэ ажээ. Түүний аав Борнуурын “Дөрвөн зуун үнээний ферм”-д механикчаар ажиллаж, харин ээж нь фермийн саальчин байжээ. Фермчин аав, ээж нь түүнийг өрх тусгаарлахад саалийн таван үнээ тасалж өгсөн нь өдгөө бидний харж буй үнээний фермийн суурийг

тавьсан гэдэг. Эднийх сүүний чиглэлийн 30 саалийн үнээтэй. Сумын төвийн айлуудаас гадна, “Витафит” үйлдвэр, “Урхан” ХХК-нд сүүгээ нийлүүлдэг томоохон хамтрагч. Өдгөө сүүний хамгийн бага гарцтай улирал хэдий ч өдөрт 200 литрээс бага сүү авдаггүй байна.

Төгсгөл нь VI нүүрт

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧ: Б.ОЮУНГЭРЭЛ	ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ: Б.ӨНӨРТОГТОХ 88006842	УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН АЛБА: Б.ПҮРЭВЖАВ 99210031	КОМПЬЮТЕР, ГЭРЭЛ ЗУРГИЙН АЛБА: Б.ГАНЗОРИГ 99998796	Улсын бүртгэлийн дугаар: 907300528 Индекс: 100757
	ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: Н.ПУНЦАГБОЛД 88096454	ЭРЭН СУРВАЛЖЛАХ, ШУУРХАЙ МЭДЭЭЛЛИЙН АЛБА: С.БУДРАГЧАА 90005522	САНХҮҮ, МАРКЕТИНГИЙН АЛБА: М.ДАВААДУЛАМ 99042510	Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар. 209, 210, 211 тоот
ФЭЙСБҮҮК: www.facebook.com/mongoliinmedeesonin/		ТВИТТЕР: www.twitter.com/MongoliinMedee		“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-гийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

МАН, МАХН-ЫН ХОЁР, АН-ЫН ЗУРГААН УЛСТӨРЧ ХЭЦҮҮ НЭРТЭД ХОРИГДЖЭЭ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Мэдээж өөрийн намын улстөрдөө хамгаалж үлдээд өрөөлийг намнаж байна гэх муу нэрнээс салахын тулд нэгэн цагт намынх нь туг болж, Гүйцэтгэх засаглалыг тэргүүлж явсан С.Баярыгаа бүтэн сар хорьж “гэнэтийн бэлэг” барьсан юм. Харин өчигдөр экс Ерөнхий сайдуудыг үргэлжлүүлэн хорих шийдвэрийг шүүхээс гаргасан юм. Тэгвэл Оюутолгойн гэрээг зурсан гэх “хам хэрэгтэн” С.Баярцогтыг дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэсэн үндэслэлээр өнөөг хүртэл хорьсон хэвээр байна. Тэр энэ өдрүүдэд бусад шигээ бие нь муудаж эмнэлэгт хүргэгдсэнгүй. Бас захидал бичиж гоншигооноогүй. Тэгвэл төрийн өндөр албан тушаал хашч байсан улстөрчид ямар хэргээр хэдэн хоног хоригдож, мөн ял авч байсныг нь тоймлон хүргэе. Тэдний дийлэнх нь хоригдож байхдаа биений байдал муу, сахарын өвчинтэй гэх мэт шалтгаан хэлж суллагдаж байжээ.

Н.Энхбаяр /МАХН/
Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан энэ эрхэм 2012 онд хэцүү нэргийн хаалга татсан. Хоригдож байх хугацаандаа өлсгөлөн хүртэл зарлаж, оймстойгоо ачигдаж байсан дуулианыг өнөө хэр мартаагүй. Түүнд мөн л авлига, албан тушаалаа урвуулан ашигласан гэх үндэслэлээр ял тулгаж байлаа. Харин 2013 онд түүнийг Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдоржийн шийдвэрээр өршөөл үзүүлэн суллаж байсан юм.

Ц.Батбаяр /МАН/
Нийслэлийн Засаг дарга асан, МАН-ын гишүүн Ц.Батбаярыг АН ялсан үед өмч хувьчлалын комиссын даргаар ажиллах үедээ албан тушаалаа урвуулан ашигласан хэргээр шалгаж эхэлсэн юм. Улмаар, 2014 онд түүнд 2.1 жилийн хорих ял оноож цагдан хорив. Харин хоригдох хугацаанд засрал хүмүүжил сайн, төлбөрийн өргүй байсан гэх үндэслэлээр түүнийг 2015 оны аравдугаар сард суллажээ. Суллагдах хугацаан нь 2016 оны наймдугаар сард байсан ч хугацаанаас өмнө сулласан билээ.

Я.Батсуурь /АН/
Тэр АН-ын гишүүн. Мөн “Эрдэнэс Тавантолгой” компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байлаа. Харин тус компанийн захирлаар ажиллаж байхдаа Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийн хүргэн Г.Дэнзэнгийн удирддаг “Говь повер” компанид давуу эрх олгож, 4.6 тэрбумын тендер өгсөн гэх хэрэгт холбогдож, 2015 онд түүнийг цагдан хорьсон юм. Улмаар 2017 онд түүнд хоёр жилийн хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэж байлаа.

Г.Шийлэгдамба /МАХН/
МАХН-ын гишүүн тэрбээр, авлига авсан хэргээр хоригдсон. Эрүүл мэнд, спортын сайдаар ажиллаж байх үедээ албан өрөөндөө авлига авч байсныг нь гүйцэтгэх ажиллагаа явуулан илрүүлж байв. Төрийн өндөр албан тушаалтан үйлдэл дээрээ баригдсан анхны тохиолдол тэр байлаа. Г.Шийлэгдамба эрүүл мэндийн шалтгаанаар батлан даалтад гарсан ч буцаад хоригджээ.

Н.Батбаяр /АН/
УИХ-ын гишүүн асан Н.Батбаярын тухайд 2017 оны хоёрдугаар сарын 22-нд баригдсан юм. Түүнд “Гудамж” төслөөс их хэмжээний мөнгө завшсан, мөн бусдад давуу эрх олгосон гэх үндэслэлээр хэрэг үүсгэж шалгаж эхэлсэн байдаг. Нийтдээ 14 хоног цагдан хорьсны дараа эрүүл мэндийн байдлыг нь харгалзан үзэж суллаж байлаа. Одоо түүнийг гадуур байцааж, хэргийг нь шалгасаар байна.



Б.Гарамгайбаатар /АН/
УИХ-ын гишүүн асан Б.Гарамгайбаатар мөн л Гудамж төсөлтэй холбоотой хэргээр баригдаж байв. Өөрөөр хэлбэл, Халзан бүргэдэй, Солонготын давааны замын ажил 38 хувьтай байхад тус газар шинээр зам тавина хэмээн Хөгжлийн банкаас мөнгө гаргуулсан хэрэгт холбогдож мөн л 14 хоног хоригдсон юм. Түүнийг 2017 оны гуравдугаар сарын 06-нд эрүүл мэндийн шалтгааны улмаас суллаж, хэргийг нь жил гаруйн хугацаанд шалгалаа. Харин энэ оны дөрөвдүгээр сарын сүүлээр түүний хэргийг хэрэгсэхгүй болгосон юм.

Н.Золжаргал /АН/
Монголбанкны Ерөнхийлөгч асан Н.Золжаргалыг өнгөрөгч оны арваннэгдүгээр сарын 29-нд цагдан хорьсон юм. Түүнийг гурав хоног хорьсны дараа арванхоёрдугаар сарын 01-нд суллаж, гадуур байцаахаар шийдэж байлаа. Н.Золжаргалыг “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхдээ их хэмжээний мөнгө хувьдаа завшсан гэх үндэслэлээр шалгаж байгаа билээ.



Ч.Сайханбилэг /АН/
Экс Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн тухайд Оюутолгойн далд уурхайн гэрээ эхлүүлэхдээ давуу эрх олгосон, татварын өрөөс чөлөөлсөн гэх үндэслэлээр хэрэгт холбогдон шалгуулж байна. Түүнийг өнгөрөгч дөрөвдүгээр сарын 10-нд цагдан хорьсон бол өчигдөр үргэлжлүүлэн хорих эсэх шүүх хурал болж, дахин нэг сар хорихоор шийдвэрлэв. Ч.Сайханбилэгийн тухайд хорих ангиас захидал илгээсэн бөгөөд цагдан хорьсон нэг сарын хугацаанд нэг л удаа байцаалт авсныг мөн хэлж байлаа.

С.Баярцогт /АН/
УИХ-ын гишүүн, Сангийн сайд асан С.Баярцогтыг мөн л Оюутолгойн асуудлаар цагдан хорьж буй. Ил уурхайн бүтээн байгуулалт эхэлсэн 2009 онд Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахдаа “Рио Тинто” компанид давуу эрх олгосон, их хэмжээний авлига авсан байж болзошгүй гэх үндэслэлээр түүнийг шалгаж байгаа юм. Түүнийг мөн л өнгөрөгч дөрөвдүгээр сарын 01-нд цагдан хорьсон юм. Үргэлжлүүлэн хорих эсэх шүүх хурал энэ сарын эхээр болж, үргэлжлүүлэн хорих шийд гаргасан билээ.

С.Баяр /МАН/
Экс Ерөнхий сайд С.Баярыг Ч.Сайханбилэгтэй хамт цагдан хорьсон. Хоригдож байх хугацаандаа тэрбээр бие нь муудаж мөн л эмнэлэгт хүргэгдэж байлаа. С.Баярыг Оюутолгойн гэрээг үзэглэхдээ давуу эрх олгож, мөн авлига авсан байж болзошгүй гэх хэрэгт холбогдуулан шалгаж байгаа. Түүнийг өчигдөр мөн үргэлжлүүлж хорихоор болов.



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : **2018.05.11**
Тендер шалгаруулалтын нэр: Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Улаанбаатар, Хан-уул дүүрэг, 53 дугаар цэцэрлэг БСПУСЯ/201801162

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам эрх бүхий тендерт оролцогчдоос ХШ.1.1.1.162 **Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Улаанбаатар, Хан-уул дүүрэг, 53 дугаар цэцэрлэг/ ажлыг гүйцэтгэх** тухай тендер ирүүлэхийг урьж байна.
Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажилгааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулах зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.
Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000.00 /Тавин мянга/** төгрөгийн цахим систем ашиглан төлсөн байх шаардлагатай.
Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017 онуудын борлуулалтын орлогын дундаж нь 800,000,000 /Найман зуун сая/ төгрөгөөс багагүй байна.**
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **400,000,000.00 /Дөрвөн зуун сая/ төгрөгөөс багагүй байна**
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Шаардлагагүй.**
Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017 онуудад доод тал нь нэг удаа 600,000,000.00 /Зургаан зуун сая/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.**
Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:
- 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт,
- 2.1.2. Цутгамал болон угсармал

төмөр бетон, мод ба өргөт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил (1- 5 давхар хүртэл)
- 2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт,
- 2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулгүйн дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт /Түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгчид нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна./
Тендерийн баталгааны дүн: 12,000,000.00 (Арван хоёр сая) төгрөг.
Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем цахим тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн

сангаас тендерт оролцогчийн цахим тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.
Тендерийг **2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байшцуулан тендерийг **2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 10 цаг 20 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.
Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулдаг цахим худалдан авах ажиллагааны төлбөргүй сургалтанд хамрагдахыг зөвлөж байна.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Засгийн газрын III байр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, 1 дүгээр давхар 516 - 6 тоот. Санхүү, хөрөнгө оруулалтын газар
Утас: 11-320358
Цахим хаяг: www.tender.gov.mn

ШҮҮХИЙН ТАНХИМААС



МЭДЭЭЛЭЛ

Авто машины
хулгайч бүлэг
этгээдүүдийг
илрүүллээ

Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ

Баянзүрх дүүргийн 18 дугаар хороонд оршин суух Т-ын эзэмшлийн “Mitsubishi kolt”, мөн тус дүүргийн нэгдүгээр хороонд оршин суух Б-ийн эзэмшлийн “Toyota Pruis-10” маркийн автомашинуудыг Сонгинохайрхан дүүрэгт оршин суух хаягтай М, Ч нар бүлэглэн хулгайсныг Нийслэлийн цагдаагийн газрын Мөрдөн шалгах газрын алба хаагчид шуурхай илрүүлжээ. Сүүлийн үед автомашин хулгайлах гэмт хэрэг ихсэж байгаа тул иргэд та бүхэн автомашинаа харуул хамгаалалт, хяналтын камер, гэрэлтүүлэгтэй зогсоолд байршуулж, нүдэнд ил харагдах газар цүнх болон эд зүйл орхихгүй байхыг Нийслэлийн цагдаагийн газраас анхаарууллаа.

Хүнд түлэгдсэн
иргэнд
Д.Сарангэрэл
сайд туслажээ

Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ

Өнгөрсөн лхагва гарагийн шөнө Говь-Алтай аймгийн Цогт суманд 36 настай иргэн Б бензинийг устай андууран халуун тогоо руу хийсний улмаас их хэмжээгээр хордож, биеийнх нь 80 хувь түлэгджээ. Аймгийнхаа нэгдсэн эмнэлэгт хүргэгдсэн иргэн Б-гийн биеийн байдал хүнд байгаа учраас яаралтай нийслэл хотод ирж эмчлүүлэх шаардлагатай болсон ч онгоцны суудал дүүрсэн гэх асуудал тулгарчээ. Харин тус аймагт ажиллаж байсан Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл энэ асуудлыг газар дээр нь шийдвэрлэж, тухайн иргэнийг яаралтай Улаанбаатар хот руу явуулсан байна.

ЕРӨНХИЙ САЙД АСАН Ч.САЙХАНБИЛЭГ, С.БАЯР НАРЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХОРИХООР БОЛОВ



Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ
ts.chandmanierdene@gmail.com

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Ч.Сайханбилэг, С.Баяр нарыг Оюутолгойн болон Дубайн гэрээтэй холбогдуулан, нэг сарын хугацаагаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан билээ. Тэгвэл Нийслэлийн прокурорын газраас Ч.Сайханбилэг, С.Баяр, ТЕГ-ын хэлтсийн дарга Б.Бадрал нарт цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан хугацаа дуусч байгаагай холбогдуулан хорих хугацааг дахин нэг сар сунгуулах тухай санал ирүүлснийг өчигдөр Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хэлэлцлээ. Чингэлтэй дүүргийн шүүх Ч.Сайханбилэг С.Баяр, ТЕГ-ын хэлтсийн дарга Б.Бадрал нарыг цаашид үргэлжлүүлэн цагдан хорих шаардлагагүй хэмээн үзэж, хилийн хоригтойгоор батлан даалтад гаргах шийдвэрийг гаргасан талаар 13:00 цагт тус шүүхийн

тамгын газрын хэвлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн З.Баяржаргал сэтгүүлчдэд мэдээлсэн юм. Шүүх хурлын дараа Ерөнхий сайд асан С.Баярын өмгөөлөгч А.Ариунаа “Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлэх шаардлаггүй гэж шүүх үзлээ. С.Баярын биеийн байдал сайн байгаа” хэмээн мэдэгдсэн юм.

ТЕГ-ын хэлтсийн дарга Б.Бадралын өмгөөлөгч П.Эрхэмбаяраас шүүх хурлын талаар цөөн асуултад хариулт авлаа.

-Б.Бадралыг үргэлжлүүлэн хорих асуудлыг хэлэлцээд шүүх ямар шийдвэр гаргасан бэ? -Нийслэлийн прокурорын газраас хорих хугацааг дахин 30 хоногоор сунгах саналтай орж ирсэн. Мөрдөн байцаах ажиллагааны явцад Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрх маш ноцтойгоор зөрчигдөж байдаг учир асуудлыг яаралтай мөрдөн шалгаж шийдвэрлэж байх ёстой. Өнөөдрийн хуралдаанаар дээрх асуудлыг

авч хэлэлцсэн. Дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй байна.

-30 хоногийн хугацаанд цагдан хоригдсон хүмүүсээс хэдэн удаа мэдүүлэг авсан бэ?

-Янз янз л байх шиг байна. Зарим нь дөрөв, зарим нь гурван удаа мэдүүлэг авсан байна. Мөн нэг удаа мэдүүлэг авсан хүн ч байх шиг байна.

-Таны үйлчлүүлэгчийн биеийн байдал ямар байна?

-Урьдчилан хорих ангид хүний бие сайн биш байх нь ойлгомжтой. Хэдийгээр тэнд цагдан хоригдож байгаа боловч сэтгүүлчдээр дамжин нийгэмд нэр төрөөрөө цоллуулж олон нийтэд зарлагдаж байгаа нь хүний эрхийг зөрчиж байна.

-Б.Бадрал хэзээнээс эхлэн цагдан хоригдож байна вэ?

-Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй. Хуульзүйн тусалцаа үзүүлэх гэрээгээр нөгөө хүндээ үүрэг хүлээх, хариуцлага хүлээх үйлчлүүлэгчийн хүсэл зорилго байгаа учир хэнийг өмгөөлж байгаа вэ. Ямар албан тушаалтан ямар хэрэгт холбогдсон бэ гэдэг талаар мэдээлэл өгөх ямар ч боломж байхгүй.

Шүүх хурлын дараа ИШШГЕГ-ын харьяа хорих 461 дүгээр ангийн гадна Ерөнхий сайд асан Ч.Сайханбилэгийн өмгөөлөгч сэтгүүлчдэд мэдээлэл хийсэн юм.

Л.Данзанноров:
Мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилнэ

“Манай үйлчлүүлэгчийг улсаас их хэмжээний мөнгө завшсан хэрэгт буруутган шалгаж байна гэсэн ташаа мэдээлэл нийгэмд байна. Прокурорын яллагдагчаар татсан тогтоолд авлига хээл хахууль авсан тухай нэг ч өгүүлбэр байхгүй. Гагцхүү Засгийн газрын сайд байх үед танхимаараа хэлэлцэн гаргасан шийдвэрийг хууль хяналтын байгууллага, прокурор, АТГ хэлэлцэж байгаа нь буруу гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хуульд Засгийн газрын бодлогын шийдвэрийг хэрхэн авч хэлэлцэх вэ гэдгийг тодорхой заачихсан байгаа. Тодруулбал, Үндсэн хуулийн 35.2-т “Засгийн газрын шийдвэрийг буруу гэж үзэх юм бол Засгийн газар өөрөө эсвэл УИХ хэлэлцэж хүчингүй болгоно гэсэн заалт бий.

Гэтэл тов тодорхой зохицуулалттай зүйлийг хууль хяналтын байгууллага хэлэлцэж байна. Цаацдаа мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилнэ” хэмээлээ. Өчигдөр 15.00 цагийн үед Чингэлтэй дүүргийн шүүхээс гаргасан Ерөнхий сайд асан С.Баяр, Ч.Сайханбилэг нарыг суллах шийдвэрийг прокуророос эсэргүүцэж, Чингэлтэй дүүргийн ерөнхий шүүгчид гомдол гаргасан юм. Шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж, Ерөнхий шүүгчид гомдол гаргах эрх прокурорт байдаг аж. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчид прокурорын эсэргүүцлийг хүлээн авч хянаад: “С.Баяр, Ч.Сайханбилэг, Б.Бадрал нарын таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилсөн шүүгчийн захирамж үндэслэл тодорхойгүй” гэсэн үндэслэлээр уг шүүгчийн захирамжийг хүчингүйд тооцож, прокурорын гомдлыг хангаж шийдвэрлэлээ. Ингэснээр С.Баяр, Ч.Сайханбилэг, Б.Бадрал нарыг тус бүрийн цагдан хорих хугацааг нэг сараар сунгалаа. Шүүх хуралд дээрх хүмүүсийн өмгөөлөгч нар ирээгүй байна.

ХӨНДӨХ СЭДЭВ

Жендэрийн хуулийг хэрэгжүүлбэл нэг сайд огцорно

С.БУДРАГЧАА

2000-аад оны эхэн үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүд жендэр гэх гадаад үгийг ихээр хэрэглэдэг болж билээ. Тухайн үед нэлээн нэртэй улстөрч хүн телевизэд өгсөн ярилцлагадаа “Жендэр гэдэг бол хүйс гэсэн утгатай гадаад үг” хэмээн тайлбарлаж байсныг би их тод санадаг юм. Монголчуудын он удаан жил хэрэглээд хэвшсэн “хүйс” гэдэг үгийг заавал жендэр гэдэг харь үгээр солих ямар шаардлага байсныг би тухайн үед бодоод, бодоод олоогүй юм. Олон улсын донор байгууллагуудын идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр 2009 оноос Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг батлах асуудал Засгийн газар, УИХ-ын төвшинд яригдах болсныг иргэд санаж байгаа байх. Харин тэр үед би жендэр гэх үгийг “Хүүхнүүдийг дарга болго” гэсэн утгатай харь үг хэмээн ойлгодог болсон байв. УИХ 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг батлах үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэрийн тэгш байдал гэж юу болохыг нэлээн тодорхой тайлбарлах болсон бөгөөд энэ үеэс жендэр гэдэг бол “эрэгтэй

эмэгтэй хүмүүсийг нийгэмд ижил статустай байлгах” бодлого хэмээн ойлгодог болсон юм. Миний ойлголт буруу байсан уу эсвэл нийгмийн ойлголт буруу байсан уу, бүү мэд. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг хэн ч хайхрахгүй байсаар өнөөдрийг хүрсэн нь үнэн. Гэтэл бидний байдаг гэдгийг нь мэдэхгүй шахуу болтол хайхрамжгүй хандсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд тун сонирхолтой зүйл заалтууд олон байдаг аж. Уг заалтуудыг нь мэдэрч ойлгож эрх бүхий хүмүүст хүчтэй нөлөөлөх оролдлогууд ч өмнө нь огт хийгдэж байгаагүй байх юм. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлд Төрийн улстөрийн болон захиргааны томилогддог албан тушаалд хүйсийн аль нэг төлөөллийн тэгш хувийн доод хязгаарыг тогтоож өгчээ. Тухайлбал, Засгийн газар, агентлаг, аймаг нийслэлд 15 хувь, дүүрэгт 20 хувь, суманд 25 хувь, хороонд 30 хувиас доошгүйгээр хүйсийн аль нэг төлөөллийг байлгана гэх заалт байв.

Хуулийн зөвхөн энэ заалтыг бариад заргалдахад У.Хүрэлсүхийн Засгийн газрын нэг эрэгтэй сайдыг, аймаг, нийслэлийн Засаг дарга нараас дөрвийг, яамдын ТНБД нараас хоёрыг нь огцруулж оронд нь эмэгтэй хүн томилохоор байна. Цаашилбал, Засгийн газрын 27 агентлагийн даргын тавыг, 21 аймгийн ЗДТГ-ын алба хэлтсийн дарга нарын долоог, НЗДТГ-ын алба, хэлтсийн дарга нарын хоёрыг нь халж эмэгтэй хүнийг томилох ёстой болж байна. Харин сүргууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг төрийн үйлчилгээний байгууллагуудын удирдах албан тушаалыг эрхэлж 209 эмэгтэй халж, оронд нь эрэгтэй хүн томилохоор байна. Нэг сайшаалтай нь зүйл нь 2016 онд батлагдсан Сонгуулийн тухай хуульд улс төрийн аливаа нам хүчин нийт нэр дэвшигчдийнхээ 30-аас доошгүй хувийг эмэгтэй хүн байлгана гэсэн заалтыг оруулж өгчээ. Үүний үр дүнд УИХ-д 2012 онд ерөн эмэгтэй, 2016 онд 13 эмэгтэй хүн сонгогджээ. Гэвч энэ нь шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүд хүчтэй нөлөө үзүүлэхүйц хэмжээнд байж чадахгүй байна. Шийдвэр гаргах, улс

орны бодлого тодорхойлох төвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэтэрхий бага, харин гүйцэтгэх буюу хамгийн доод төвшинд эмэгтэйчүүдийн эзлэх жин харьцангуй өндөр болсон нь Жендэрийн тухайн хуулийг чанд хэрэгжүүлэх шаардлага байгааг харуулж байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсанаас хойших долоон жилийн хугацаанд Ерөнхий сайдын дэргэдэх Жендэрийн үндэсний хороо үндсэн чиг үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй бөгөөд яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ-т байгаа жендэрийн асуудал хариуцсан ажилтнууд ямар чиг үүрэгтэйгээ мэдэхгүй явсаар өнөөдрийг хүрсэн гэдэг нь 2016 онд хийсэн ХЭҮК-оос хийсэн судалгаагаар тогтоогдож байсан юм. Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах төвшин дэх оролцооны асуудал нь Монгол Улсын тулгамдсан асуудлын нэг байсаар байгаа юм. Улстөрийн томилгоотой холбоотой асуудалд сэтгүүлчид жендэрийн мэд-рэмжтэй хандаж гэмээнэ эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах төвшин дэх оролцоо бодитоор нэмэгдэх боломж бүрдэх юм.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо; **2018.05.11**
Тендер шалгаруулалтын нэр: **441 дүгээр нээлттэй хорих анги**
Тендер шалгаруулалтын дугаар: **“Байгууллагын барилгын засварт шаардлагатай материал нийлүүлэгчийн сонгон шалгаруулах” №441:2018-05**
441 дүгээр нээлттэй хорих анги нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Барилгын засварын ажилд шаардлагатай барилгын материал нийлүүлэх** тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50,000,0 төгрөг**, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.
Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд: Борлуулалтын хэмжээ: 500.000.000,0 төгрөг
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 1
Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 150.000.000,0 төгрөг
Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Шаардлагатай
Тендерийн хамт 1.230.000,0 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.
Тендерийг: 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдөр 09 цаг 30 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн, 09 цаг 30 минутад нээнэ.
Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.
Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо, 441 дүгээр нээлттэй хорих анги, ахлах нягтлан бодогч, Б.Батзаяа, утас-94996699, 98169186

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

М.Энхсайхан, С.Баярыг эргүүлэн татлаа

Б.ПҮРЭВЖАВ

Ерөнхийлөгч Х.Баттулга өчигдөр УИХ-ын дарга М.Энхболдод Элчин сайдыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай саналаа хүргүүллээ. Тус саналд Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа Элчин сайд М.Энхсайханыг эгүүлэн татаж, Шведийн Вант Улсад суух Элчин сайдаар О.Энхцэцэгийг, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суугаа Элчин сайд С.Баярыг эгүүлэн татаж, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суух Элчин сайдаар Н.Тулгыг, Япон Улсад суух Элчин сайдаар Д.Батжаргал, Канад Улсад суух Элчин сайдаар Я.Ариунболд нарыг тус тус томилох асуудлыг зөвшилцөхөөр саналд тусгасан байна.

Ц.Нямдорж: Би мэдүүлэг өгөөгүй

Б.ПҮРЭВЖАВ

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийг “Тагнуулын ерөнхий газраас байцаалт авахаар дуудсан байна. Тэрбээр энэ сарын 09-нд тус газарт очсон” гэх мэдээлэл гараад байгаа билээ. Тэгвэл энэ талаар өчигдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржоос тодруулахад “Тагнуулын ерөнхий газар гэрчийн мэдүүлэг авна гэдэг асуудал тавьсан. Би хууль хүндэтгэж очсон нь үнэн. Би мэдүүлэг өгөөгүй. Яагаад гэвэл надад гэрчлэх асуудал байхгүй. Сэтгүүлчдийг тагнаж чагнасан асуудал байхгүй. Намайг тагнуулсан, чагнуулсан гэж байгаа бол баримтаа гаргаж ир гэж хэлсэн” хэмээн тайлбарлав.

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

УБЕГ, Оюуны өмчийн газрууд салж, туурга тусгаарлах нь

Б.ПҮРЭВЖАВ

УИХ-ын 2018 оны хаврын ээлжит чуулганы өчигдөрийн хуралдаанаар хэд, хэдэн хуулийн төсөл хэлэлцэж батлав. Мөн зарим хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ. Тухайлбал, Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ. Уг тогтоолын төсөлд Иргэний бүртгэлийн байгууллагаас Оюуны бүртгэлийн газрыг салгаж, тусад нь агентлаг болгож, Хууль зүй, дотоод хэргийн сайдын харьяанд байлгахаар заасан юм. Хуулийн төсөлтэй холбогдуулан УИХ-ын гишүүд байр суурна илэрхийлэв. Тухайлбал, УИХ-ын гишүүн Д.Тэрбишдагва “Оюуны өмчийн газар болон Улсын бүртгэлийн ерөнхий газрыг 2016 онд нэгтгэсэн нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан оюуны өмчийн эрхүүдийг баталгаатай эдлүүлэх, олон улсын гэрээ конвенциор хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх боломжгүй нөхцөл байдалд хүргэсэн. Улсын бүртгэлийн хяналтын алба нь улсын бүртгэлийн ажиллагаанд хяналт тавих буюу дотогшоо чиглэсэн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Ер нь бол энэ хоёр байгууллагыг тусад нь байлгах нь зөв” хэмээн байр суурна илэрхийлэв. Мөн УИХ –ын гишүүн Д.Лүндээжанцан “Хуулийн төслийг гурван удаа хэлэлцэхэд зардал мөнгөний асуудал яригдсан. Ажлын хэсгийн зүгээс ямар нэг санхүүгийн зардал гарахгүй. Одоогийн бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулахгүйгээр агентлаг болгоход багахан хэмжээний зардал гарах ч түүнийг нь Хууль зүйн сайдын төсвөөс санхүүжүүлээд явах боломжтой гэсэн. Гүйцэтгэх засаглалыг тогтолцооны тогтвортой байдал маш чухал нөлөө үзүүлдэг учраас цаашид энэ бодлого тогтвортой байлгах талаар анхаарал хандуулна” гэсэн юм. Энэ хоёр чиг үүргийн хяналтыг нэгтгэсэн Оюуны өмч, улсын бүртгэлийн газрыг өөрчилж, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Оюуны өмчийн газар болгох агуулга бүхий тогтоолын төслийг батлахыг чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн 81.6 хувь нь дэмжлээ.

Гааль, НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийг батлав

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийв. Хуулийн төслүүдийг батлах санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 62 хувь нь Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг бүхэлд нь батлахыг дэмжив. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг бүхэлд нь батлахыг хуралдаанд оролцсон 50 гишүүний 62 хувь нь дэмжиж баталлаа. Хуулиудыг баталснаар импортоор оруулж ирж байгаа тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан (OSB), стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийц, гуалингаас бусад бүх төрлийн түлшний зориулалттай модыг гаалийн албан татвараас, ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил болон импортоор оруулж ирж байгаа тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан (OSB), стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийц, гуалингаас бусад бүх төрлийн түлшний зориулалттай модыг НӨАТ-аас 2022 оны арванхоёрдугаар сарын 31-ний өдрийг хүртэл тус тус чөлөөлөх юм.

ӨДРИЙН ТОДРУУЛГА

Н.ГАНИБАЛ: “Монголоо сонсьё” үндэсний аяны бэлтгэл ажил хангагдлаа

Б.ӨНӨРТОГТОХ

Ардчилсан натаас зохион байгуулж буй “Монголоо сонсьё” үндэсний аян 2018 оны тавдугаар сарын 14-ний 11.30 цагт “Blue sky” зочид буудлын хурлын танхимд нээлтээ хийх гэж байна. Үндэсний хэлжээний энэхүү аяны бэлтгэл ажлын явцын талаар Ардчилсан натын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга Н.Ганибалаас тодруулаа.

-Ардчилсан нам анх удаа сонгуулийн бус цагаар үндэсний хэмжээний томоохон аяныг зохион байгуулах гэж байна. Бэлтгэл ажил хэдэн хувьтай байна вэ?

-“Монголоо сонсьё” үндэсний аяны бэлтгэл ажил хангагдлаа. УБХ-ны гишүүд маань орон нутагт ажиллахдаа намын шинэчлэлийн талаар, улс төрийн байр суурь, Ардчилсан намын үзэл баримтлалын шинэ төслийг нийтэд танилцуулж, хэлэлцүүлж, гишүүд, дэмжигчид, иргэдийн саналыг авах зэрэг ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Намын шинэчлэгдсэн дүрэм анхан шатандаа хэрхэн хэрэгжиж байгаатай танилцах, ололт хийгээд алдаа, дутагдлын талаар гишүүд, дэмжигчдийн саналыг сонсох, бодлогын зөвлөл, салбар хороодын танилцуулгыг хийж газар дээр нь зохион байгуулах гэсэн үндсэн үүрэгтэй ажиллаж байна. Бэлтгэл ажлыг хангах хүрээнд бид өнгөрсөн долоо хоногт нийслэлийн Баянгол дүүрэг болон Төв аймгийн Батсүмбэр суманд тус тус “Жишиг нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгуулсан. Хэрхэн үр дүнтэй өдөрлөг зохион байгуулах вэ, иргэд, гишүүд, дэмжигчдэд хэрхэн мэдээллээ хүргэх вэ гэдгийг энэхүү жишиг өдөрлөгт оролцсон хүмүүс харсан байх.

-Аяны нээлт хэзээ вэ?

-“Монголоо сонсьё” үндэсний аян цаг хугацааны хувьд 2018 оны энэ сарын 14-өөс зургаадугаар сарын 14-ний өдрүүдэд буюу бүтэн сарын турш үргэлжилнэ. Нээлтийн арга хэмжээ 2018 оны тавдугаар сарын 14-ний 11.30 цагт “Blue sky” зочид буудлын хурлын танхимд зохион байгуулахаар төлөвлөөд байна. Нээлтийн арга хэмжээнд Ардчилсан намын удирдлагууд, нийт гишүүд, дэмжигчдийн төлөөлөл

ТОМИЛОЛТ

Эгч, дүү есөн өнчин охинд хоёр өрөө байр бэлэглэлээ



Б.ӨНӨРТОГТОХ

Ерөнхий сайд У.Хүрэлсүх энэ сарын 7-10-ны өдрүүдэд орон нутагт ажиллаж, хөдөөгийн иргэдийн санал хүсэлтийн дагуу очсон аймаг бүртгээ шийдлээ хүлээсэн асуудлуудыг шийдвэрлэж явна.

Гүйцэтгэх засаглалын тэргүүн энэ сарын 08-ны өдөр Баянхонгор аймагт ажиллахдаа аав, ээж нь авто ослоор өөд болсон эгч, дүү есөн охинд хоёр өрөө байрны түлхүүр гардуулав. Өнчин охидыг нагац эгч нь харж, ханддаг аж. Бага охин нь таван настай, том эгч нь энэ жил оюутан болсон. Тэд орон байр хүсч аймгийнхаа Засаг даргын тамгын газарт хандсан байжээ. Энэ асуудал өмнө нь Засгийн газрын түвшинд яригдсан бөгөөд хүүхдүүдийн орон сууцны асуудлыг шийдэж өгөх чиглэлийг Ерөнхий сайд У.Хүрэлсүх өгсөн байжээ.

Аймгийн ЗДТГ-аас хоёр өрөө орон сууц бэлэглэхээр болж, Ерөнхий сайдын тус аймагт ажиллах үеэр түлхүүрийг нь гардуулжээ.

ХӨЛСНИЙ АМТ



УДАМ ДАМЖСАН ФЕРМЕР

Үргэлжлэл. Түүрүүч нь II нүүрт

...Тэртээ 1999 онд хөдөөгийн фермийн хүдэр улаан залуу Улаанбаатарын унаган охинтой заяа холбож, турьхан биетэй, уяхан аальтай хотын охин фермийн саальчин болжээ. Тэр цагаас хойш өнөөг хүртэл хотын танхил охин малын баастай зууралдлаа гэж гомдлохгүй, жавартай өдрийн нар, жаргалтай өдрийн чимэг байж хамтдаа зүтгэсээр хоёр залуу өнөөдрийг хүрч хөдөлмөрийнхөө үрийг хүртэн сайхан амьдарч байна...

Авсан сүүгээ долоо хоногийн пүрэв, ням гарагуудад хот руу оруулж борлуулагч цэгүүдээрээ тараадаг байна. Арав гаруй жил энэ маршрутаар ажилласан тэрбээр хэд, хэдэн байнгын үйлчлүүлэгчтэй болжээ. Сүхбаатар дүүргийн нэгдүгээр хорооны хөгшчүүд тэдний сүүг андахгүй. Хотынхоо хэдэн хөгшнийг сүүгээр нь тасалчихгүйн тулд товлосон өдрөө, болзсон цагтаа фермийн эзэн Баяраа портер машиндаа сүүгээ ачсаар ирэхийг нь тэд амдан тосч дугаарлан зогсоод сүүгээ авцгаадаг аж. Сумынхаа айлуудад сүүнийхээ литр тутмыг нь зундаа 500-600

төгрөгөөр, өвөлдөө 1200 төгрөгөөр худалдаалдаг. Харин Улаанбаатарт авчирсан сүүгээ литр тутмыг 1600 төгрөгөөр зардаг байна. Фермийн үнээ асаргаа их шаарддаг гэнэ. Бэлэн тэжээл хомсдоод ирэхэд өдрийн цагаар хэсэгхэн бэлчээрт гаргахад л ядарч сульдаад сүүний гарц нь мууддаг аж. Фермийн аж ахуй эрхлэгчийн “шүдний өвчин” болсон асуудлын нэг нь малын өвс тэжээл байдаг тул Баяраа зуншлага сайтай газар дамжин хадлангийн талбай түрээслэдэг хэмээн ярьж байлаа. Гэвч өвсний ургац гүйцэх үед гэрийн бараа харалгүй, хөдөлмөрлөж байж бэлтгэсэн өвс нь хаанаа ч хүрдэггүй байна. Үнээнийхээ сүүний гарцыг бодож саалийн үнээгээ аль болох бэлчээрт гаргахгүй тэжээдэг хэмээв. Өвлийн улиралд сувай болон эр үхрүүдээ ч бэлчээрт гаргадаггүй байна. Баяраа өнөөдрийн байдлаар саалийн болон сувай, эр нийлсэн 80 гаруй үхрийг тэжээж байна. Намар хадсан өвс нь жилийн турш үхрээ тэжээхэд

хүрэлцдэггүй учраас улаан буудайн шаарыг нэмэлтээр өгдөг аж. Буудайн шаар 90 градусын халуун байдаг учраас үнээний унданд зохимжтой гэнэ. Хорголжин, хивэг гэх мэт бусад тэжээлүүд өндөр үнэтэй тул тэр бүр аваад байдаггүй аж. Тиймээс өртөг бага, өгөөж сайтай боломжийн тэжээл нь улаан буудайн шаар ажээ. Түүний аав залуу насаа үнээний фермд хөдөлмөрлөж өнгөрөөсөн нэгэн бөгөөд тэрбээр одоо ч фермдээ ажиллаж байна. Аавынх нь ферм 20 гаруй саалийн үнээтэй аж. Б.Баяржаргалын бага дүү мөн л фермийн аж ахуй эрхэлдэг байна. Гурван фермийн 70 гаруй үнээнээс өдөрт 400 литр сүү авдаг ажээ. Фермийн их ажлынхаа хажуугаар тэрбээр хурдан морь уяж сойдог морины хорхойтон. Дурлах төдийхнөөр ярих дулимагхан уяач ч биш. Түүний хурдан хээр морь баргийн адуунд түрүүгээ өгөхгүй шандастай хүлэг ажээ. Сумын нааддамдаа айргаас мултардаггүй гэнэ лээ. Мал дагавал ам тосдоно

гэгчээр хүүхэд ахуйдаа Герман хүүхдүүдтэй дэгдэж явсан буйран дээрээ өдгөө үнээний ферм ажиллуулж, өргөн олондоо үлгэрлэн амьдарч байна. Түүнийг хүүхэд байхад энэ фермийн байранд Герман улсын мэргэжилтнүүд амьдардаг байжээ. Наран цэцэг найгаж, Герман, Монгол хүүхдүүд буужигнасан сайхан газар байсныг Баяраа дурсан яриw. Түүнд эзэн хүний ихэмсэг зангийн үнэр ч байхгүй нэгэн ажээ. Фермийнхээ ажилчдын хамт үнээний баас цэвэрлэж, малынхаа тэжээлийг өгөөд л хээ шаагүй алхаж явах... Малынхаа идэш тэжээл, асаргаа арчилгаанаас эхлээд сүүний борлуулалт, тээвэрлэлт, маркетинг гээд бүгдийг өөрөө хийнэ. Мэдээж үүний ард сайн хань байгааг мартаж болохгүй. Тэртээ 1999 онд хөдөөгийн фермийн хүдэр улаан залуу Улаанбаатарын унаган охинтой заяа холбож, турьхан биетэй, уяхан аальтай хотын охин фермийн саальчин болжээ. Тэр цагаас хойш өнөөг хүртэл хотын танхил охин малын баастай зууралдлаа гэж гомдлохгүй, жавартай өдрийн нар, жаргалтай өдрийн чимэг байж хамтдаа зүтгэсээр хоёр залуу өнөөдрийг хүрч хөдөлмөрийнхөө үрийг хүртэн сайхан амьдарч байна. Б.Баяржаргалынх дөрвөн хүүхэдтэй. Том нь эрүүл мэндийн манаанд зүтгэхээр эмчийн мэргэжлээр сурдаг аж. Заяа төөрөг нь хөтөлсөн үү, угийн малд ээлтэй ч байсан уу таван үнээ нь саалийн ферм болтлоо өргөжиж, хот хөдөөгүй сүүгээр хангаж байна. Сэтгэж, сэтгэснээ биежүүлж, хөдөлмөрлөж, хөлсөө дуслуульж чадвал тавилан, төөргөд даатгаж бус өөрийн орон зай, өөрийн орчлон ертөнцийг бүтээж амьдарч болдгийг энэ залуутгийн зам мөр харуулах ажээ. Төрж өссөн халуун буйрандаа, өвгөдийн жинийг таслалгүй малынхаа буяныг хүртэж суугаа хөдөлмөрч гэр бүлд амжилт хүсье.

ӨДРИЙН ҮЙЛ ЯВДАЛ

Сэтгүүлчид шилдэг татвар төлөгчидтэй танилцав

Х.БОЛОРТЭНГИС

Жил бүрийн тавдугаар сарын хоёр дахь долоо хоногт Монгол Улсын Татварын ерөнхий газар “Татвартөлөгчдийнөдрүүд”-ийг зохион байгуулдаг уламжлалтай. Эдүгээ 19 дэх жилдээ зохион байгуулж байгаа “Татвар төлөгчдийн өдрүүд”-ийн хүрээнд энэ сарын 09-ний өдөр ТЕГ болон дүүрэг бүрийн татварын хэлтсийн удирдлагууд шилдэг татвар төлөгчидтэй уулзах “Автобустай аялал”-ыг зохион байгууллаа. Татварын байгууллагын удирдлагууд болон сэтгүүлчдийн баг 09:00 цагт Сүхбаатарын талбайгаас хөдөлж “Тэсо” корпорацийн “Хуурай сүүний үйлдвэр”-г очлоо. Тус үйлдвэрийнхэн зочдыг угтан авч өөрсдийн нэрийн бүтээгдэхүүнүүд болон үйлдвэрийнхээ талаар танилцуулав. Үүний дараа өөрсдийн үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүнээрээ дайльж, тэдгээрийг хэрхэн, яаж үйлдвэрлэдэг талаар тайлбарлаж, үйлдвэрлэх явцтай танилцуулсан юм. Тус компани 2003 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд эдүгээ 14 салбар компанитай, 1200 гаруй ажилчинтай Монгол Улсын тэргүүлэх группын нэг болон өргөжин тэлжээ. Тэргүүлэх үйлдвэрээс гадна шилдэг татвар төлөгч байгууллага болжээ. Бидний сайн мэдэх “Зөв” аарцны ундаа, “Милко” тослог сүү, “Лаша” гоймон, амтат айс маркийн зайрмагуудыг үйлдвэрлэдэг юм. Бидний танилцсан “Милко” хуурай сүүний үйлдвэр 2009 онд байгуулагдсан бөгөөд Монголын хамгийн анхны, хамгийн том хуурай сүүний үйлдвэр юм байна. Хөдөө орон нутагт малчдын гар дээрээ шингэн сүү авах хэд хэдэн цэгтэй бөгөөд тус үйлдвэрт 100 тонн үнээний сүүнээс 10 тонн хуурай сүү гардаг аж. Үйлдвэрийн аргаар үхрийн



сүүг өтгөрүүлж, улмаар өндөр температуртай халуун уураар хатаан хуурай болгон хувиргадаг байна. Ингэж гаргаж авсан сүүгээ шууд савлан зах зээлд нийлүүлдэг аж. Энэ бол бидний сайн мэдэх “Голден милк” сүү юм. “Голден милк” сүүгээрээ Монголынхоо хэрэгцээг бүрэн хангаад зогсохгүй, БНХАУ болон БНКУ-д экспортлодог байна. Маршрутын дагуу “Тэсо” корпорацийн хуурай сүүний үйлдвэрээс 11:00 цагт хөдөлж, “Эрэл” группын “Байшин үйлдвэрлэх комбинат”-д очлоо. Тус группын Ерөнхийлөгч Б.Эрдэнэбат аяллын зочдыг угтан авч үйлдвэртэйгээ танилцуулав. Тус компани байгалийн чулууг гурил шиг болтол бутлаад эргүүлэн үйлдвэрийн аргаар хиймэл чулуу

болгон ашигладаг аж. Бүтээгдэхүүнийхээ түүхий эдийг үзүүлж, үйлдвэрлэх явц, бэлэн болсон бүтээгдэхүүнээ танилцууллаа. Цэвэр байгалийн баялаг, чанартай түүхий эдээр бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг тул өндөр чанартай байдаг гэв. Үйлдвэрийн тоног төхөөрөмжөө Герман улсын хамгийн сүүлийн үеийн технологиор тоногдсон бөгөөд Германы барилгын салбарын чадварлаг инженерийн удирдлага дор үйлдвэрлэл явагддаг байна. Эндээс гарч буй барилгын хана өнгөн талдаа 40 см орчим цэвэр чулуун бүрхүүлтэй байх бөгөөд дотор давхаргууд байгалийн цэвэр хайрга, дайрга, цементээр хийсэн байх аж. Өрж угсрах илүү ажил хийлгүйгээр байшингийн нэг

талын ханыг цонхтой нь шууд угсран, ямарч зүйдэл залгаагүйгээр бэлэн болгон гаргадаг. Өөрсдийн шинэ технолоноор барьсан орон сууцаа зах зээлд нэг метр квадратыг нь 1.2 сая төгрөгөөс ихгүй байхаар төлөвлөж байгаагаа ч энэ үеэр дуулгалаа. Гэвч сайн юманд саад мундахгүйн үлгэрээр үйл ажиллагааг нь хазаарлах хүчин зүйл багагүй байгааг Б.Эрдэнэбат захирал учирлав. Түүний хэлснээр төрийн эрх баригчдын хувийн эрх ашиг ч үйл ажиллагаа нь хазаарлаад байгаа шалтгааны нэг мөн хэмээв. Байшин үйлдвэрлэх комбинатаас гарч 15:00 цагт “Грийн сити гарден” ХХК-ийн “Мөнх зун” ногооны хүлэмжинд зочлов. Тус компанийн захирал Ж.Эрхэмбаяр тусгай зориулалтын хувцас өмсгөн зочдыг хэд хэдээр хүлэмжид оруулан, ногооны ургац болоод компанийнхаа үйл ажиллагаатай танилцуулсан юм. Улаан лооль, өргөст хэмх зэрэг хүнсний ногоог өвөл зунгүй тариалах энэ хүлэмж мөн л сүүлийн үеийн тохөөрөмжөөр бүрэн тоноглогдсон аж. Ямар ч ургамал өдөрт багадаа найман цагийн турш нарны энергийг авах ёстой байдаг аж. Ургуулж буй хүнсний ногооныхоо энэхүү хэрэгцээг хангахын тулд хиймэл нар орлуулагчийг ашигладаг байна. Ногоо хураалтаас бусад бүх ажиллагаа нь ухаалагжсан байх бөгөөд ногооны усалгаа арчилгаа, дулааны хэм зэргийг бүгдийг компьютерээс удирдан явуулдаг байна. “Мөнх зун” ногооны хүлэмжээс жилдээ 40-50 тонн ургац хураан авч, зах зээлд нийлүүлдэг ажээ. Татвар төлөгчдийн өдрүүд”-ийн хүрээнд зохион байгуулсан “Автобустай аялал”-ынхан шилдэг татвар төлөгчдийн үйл ажиллагаатай танилцан 18.00 цагт аялалаа өндөрлүүлээ.

ДЭЛХИЙН ХҮН



“Сериал од” ЭРКАН ПЕТЕККАЯА

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

Эркан Петек-каяа эдүгээ Туркийн хамгийн алдартай, бас үнэтэй жүжигчдийн нэг. Гэхдээ хамгийн их үнийн дүн бүхий гэрээг “Аз жаргалын хэлтэрхий” кино дэлгэцнээ гарсны дараа хийсэн гэдэг. Энэ нь ч тус цуврал дэлхий даяар ямар их амжилтад хүрсэн бэ гэдгийн нотолгоо билээ. Тухайлбал, 2017 онд шинэ цуврал кинонд тоглохоор “Карга Се-вен пикчюрс” компанитай 10 сая фунт стирленгийн хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. Эдүгээ жүжигчин эр Лос-Анжелес хотноо кино зураг авалтад оролцож байгаа бөгөөд Турк-дээ ирж очин байдаг болжээ. Тун удахгүй түүний тоглосон Холливудын цуврал кино дэлгэцнээ гарах юм.

Эркан кино урлагт нэлээд хожуу нэрд гарчээ. Тэрбээр 1971 оны арванхоёрдугаар сарын 11-нд Днер-бакыр мужийн Чермик гэх жижиг хотод төрсөн байна. Гэхдээ тэнд төдийлөн удаан амьдраагүй бөгөөд төр-нийх нь дараа тэднийх Истанбул хот руу нүүж, тэндээ төвхнөжээ. Эцэг, эх нь хүүдээ сайн боловсрол эзэм-шүүлэхийн тулд том хотод завгүй ажиллахыг чухалчилдаг байсан гэдэг. Тэнд Эркан сайн сургуульд суралцаж, ахлах сургуулиа төгсөөд л Анатолийн үндэсний академид элсчээ. Тэр зан чанар, биеэ даасан жүжигчээг байдлаа-раа бусдаасаа ялгардаг байсан гэдгийг багш нар нь дурссан байдаг.

Анатолийн үндэсний академид элс-сэнийхээ дараа жүжиглэх ур чадвараа улам ахиулахын тулд театрыг сонгожээ. Суралцаж байх хуга-цаандаа мэргэжлийн талын бүхий л лекц, семинарыг нэг ч удаа тасалж бай-гаагүй аж. Тэр ингэж л ирээдүйн мэр-гэжилдээ өөрийг-гөө бэлдэж байж.

Хичээл зүтгэл ур чадварынхаа тус-ламжтайгаар Эркан оюутан байхдаа “Alman Avratin Bacisi” кинонд анхны дүрээ бүтээжээ. Чухам энэ дүр нь түүнд урлагийн замыг сонгосон нь буруу байгаагүй гэх итгэл үнэмшлийг тө-рүүлсэн гэдэг. Ингээд 1993 онд сургуулиа төгсөөд Истанбул хотын театрт ажиллаж эхэлжээ. Энэ бол түүний ажлын га-раа байсан юм. Театр залуу жүжигчний хувьд сурч

хөг-ж и х х а м г и й н таатай орчин байлаа. Тэнд ур чадвараа улам нэмэгдүүлж, хөгжи-хийн сацуу хажуугаар нь телевизэд ч ажиллах болсон байна. Гэхдээ алдар нэр, амжилт түүний амьдралд ирэх хүртэл тэвчээртэй хүлээх хэрэгтэй байв.

Театрт таван жил ажилласных нь дараа түүнд дэлгэцийн “Clear days” гэх кинонд дүр бүтээх санал иржээ. Тус кинонд бүтээсэн дүрээрээ өөрийнхөө авьяасыг харуулж чадсан төдийгүй ажлын шинэ туршлага хуримтлуулж чадсан юм. Гэвч, жинхэнэ нэр алдарт хүрэхийн тулд тэр дахиад 10 жил хүлээх шаардлагатай болсон. Өөрөөр хэлбэл, тэр бусад жүжигчдийн адил тийм ч хялбар алдаршиж чадаагүй нэгэн.

10 гаруй жилийн дараа Эрканд нэ-гэн боломж гарч ирсэн нь цуврал кино байлаа. Тэр “The Last Hope” се-риалд тоглосноор олонд танигдаж, алдаршсан юм. Тэр одоо Туркийн хам-гийн алдартай жүжигчин төдийгүй шүүмжлэгчид ч түүний ур чадвар, сэтгэл хөдлөлийг өндрөөр үнэлдэг гэдэг.

Ерөнхийдөө түүний үзэгчдийн таа-шаалд нийцсэн дүрүүд бүгд л цуврал киноных байдаг юм. Тиймдээ ч, түү-нийг “Сериал од” хэмээн тодор-хойлсон хэрэг. Магадгүй ма-най кино сонирхогчдын дунд тэрбээр “Аз ж а р г а л ы н хэлтэр-

хий” киноны дүр шигээ эерэг имижийг бүтээсэн байж болох хэдий ч эсрэг дүрийг ч гайхалтай сайн гаргаж чаддаг гэдгээ “Precious Time” киногоороо харуулж чаджээ. Кино дэлгэцнээ гарахаас өмнө түүний шүтэн бишрэгчид Эрканыг эсрэг дүрийг хэрхэн бүтээх бол гэдэгт эргэлзэж, эерэгээр хүлээж аваагүй гэдэг. Харин кино гарс-ны дараа түүний ү н э л э м ж хэд дахин өсчээ.

Амжилт түүнийг удаан хүлээлгэсэн. Гэхдээ тэр одоо хамгийн алдартай нэгэн, бас аз жаргалтай өрхийн тэргүүн болж чадсан юм. Тэрбээр Димен гэх нөхрийнхөө ажлыг ойлгодог, дэмждэг үзэсгэлэнт бүсгүйтэй 2003 онд гэрлэжээ. Жүжигчин эр хуримын ёслолд оролцож байхдаа эхнэртээ анхны харцаар дурлаж, түүнээс хойш жил орчим болзсоныхоо дараа сүй тавьсан гэдэг.

Э р к а н кино урлагт хожуу амжилтад хүрсэн шигээ ху-вийн амьдралаа ч хожуу эхлүүлжээ. Хэдий тийм ч түүнийг аз-тай эр гэж тодорхойлоход хэ-тийдэхгүй. Амжилт түүнийг удаан хүлээлгэсэн. Гэхдээ тэр одоо хамгийн алдартай нэгэн, бас аз жаргалтай өрхийн тэргүүн болж чадсан юм. Тэрбээр Димен гэх нөхрийнхөө ажлыг ойлгодог, дэмждэг үзэсгэлэнт бүсгүйтэй 2003 онд гэрлэжээ. Жү-жигчин эр хуримын ёслолд оролцож байхдаа эхнэртээ анхны харцаар дурлаж, түүнээс хойш жил орчим болзсоныхоо дараа сүй тавьсан гэдэг. Хосууд нэг хүүтэй. Хүү нь эдүгээ 10 настай аж. Харин дахин хүүхэдтэй болох талаар Эркан “Оройтсон” гэх үзэлтэй гэнэ. Нэгэн удаа сэтгүүлч түүнээс дахин хүүхэдтэй болохыг хүсч байгаа эсэх талаар асуухад нь “Дахин хүүхэдтэй болоход оройтсон байх” хэмээн ха-риуулж байсан удаатай.

Жүжигчин эрд нэ-гэн онцлог имиж бий. Энэ нь гадаад төрх, хувцас-л а л т

биш бөгөөд тэр баруун гарынхаа ядам хуруунд хар өнгийн шигтгээ бүхий бөгжийг байнга зүүдэг юм. Тэгвэл энэ бөгжөө хүүгээ төрөхөд захиалгаар хийлгүүлж байжээ. Хүүгээ том болж, 18 нас хүрснийх нь дараа тус бөгжөө бэлэглэх зорилгоор нэг ч удаа ху-руунаасаа салгадаггүй гэдэг.

Эркан сэтгүүлчидтэй ойр харил-цаатай, нээлттэй нэгэн гэнэ. Тэрбээр ярилцлага авах хүсэлтэд тэр бүр та-галздаггүй бөгөөд заримдаа гэртээ урих тохиолдол ч байдаг аж. Мөн тэр-бээр мэргэжлийн ажлынхаа хажуугаар гэр бүлийн эдийн засгаа дэмжихийн тулд ногооны аж ахуй, худалдаа эр-хэлдэг гэнэ. Өөр нэгэн сонирхолтой баримт нь “The Shards” цуврал кинонд тоглохдоо Эркан жингээ нэлээд ха-сах шаардлагатай болсон гэдэг. Гэхдээ турсаныхаа дараа биедээ тун чиг сэтгэл хангалуун байх болсон гэнэ лээ. Тэр зөвхөн Турк төдийгүй Ойрхи Дорнодын шилдэг жүжигчин шагналыг хүртэж байжээ. Энэ нь түүний хамгийн хайртай шагналын нэг аж.

“Аз жаргалын хэлтэрхий” киноны-хоо дүрээр манай үзэгчдийн сэтгэлд хоногшсон Туркийн жүжигчин Эр-кан Петеккаяагийн амьдралын ту-хай сонирхуулахад ийм байна. “Аз жаргалын хэлтэрхий” киноныхоо дараа тэрбээр асар их мөнгөн дүн бүхий уран бүтээлийн гэрээ хийж чадсан гэдгийг дээр дурьдсан билээ. Тиймээс тэр удахгүй АНУ-ын өөр нэгэн цуврал киногоор эргэн ирэх нь дамжиггүй.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Малайзад амиа алдсан монгол бүсгүйн эцэг тэмцлээ үргэлжлүүлсээр байна

Б.ДАВААХҮҮ

Одоогоос 12 жилийн өмнө буюу 2006 оны аравдугаар сард Монгол Улсын иргэн Ш.Алтантуяа Малайзад учир битүүлгээр амиа алдсан билээ. Тухайн үед Малайзын нөлөө бүхий улстөрчидтэй холбогдож байсан орчуулагч бүсгүйн толгой руу буудаж, биед нь С4 гэх тэсрэх бодис зүүж дэлбэлснийг шинжээчид тогтоосон байдаг.

Эл хэрэгт хохирогчийн ар гэрийнхэн болон сөрөг хүчин, хэвлэл мэдээллийн агентлагууд Ерөнхий сайд Нажиб Разацыг олон жилийн турш буруутгаж байгаа ч, хэргийн учиг өнөөдрийг хүртэл бүрэн тайлагдаагүй байгаа юм. Түүнчлэн, Ш.Алтантуяа агсны эцэг С.Шаарийбуу 10 гаруй жилийн турш охиныхоо амийг Малайзын талаас нэхэж, хүний эрхийн олон ч байгууллагад хандсан хэдий ч тусыг олж чадаагүй билээ.

Гэсэн ч тэрбээр өнөөдөр ч тэмцлээ үргэлжлүүлсээр байгаа аж. Малайзад саяхан парламентын сонгууль болсон юм. Тэгвэл тус сонгуулийн санал хураалт болохоос нэг хоногийн өмнөөс С.Шаарийбуу гуай Малайзад очиж, эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлжээ. Тэрбээр малайзчууд болон экс Ерөнхий сайд Махатир Мохамад нарт хандан мэдэгдэл хийсэн бөгөөд түүндээ “Малайзчууд аа, сонголтоо хийхдээ Ш.Алтантуяаг санаарай. Хэрэв Малайзын ард түмэн буруу сонголт хийвэл миний охины аллага шиг шударга бус явдалтай нүүр тулах болно” гэжээ. Их сургуулийн багшаар ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан тэрбээр гуравхан өгүүлбэртэй мэдэгдэлдээ гарын үсгээ зурж, Малайзын туг барьсан гэрэл зургийн хамт илгээсэн байна. Түүний хувьд энэ сонгуулиар шинэ Засгийн газар бүрэлдээсэй хэмээн хүсч байгаа аж. Ш.Алтантуяа агсан эдүгээ амьд сэрүүн байсан бол тавдугаар сарын 06-нд 40 нас хүрэх байжээ.

Ямартай ч, С.Шаарийбуугийн тэмцэлд үр дүн гарч, парламентын сонгуульд сөрөг хүчин ялалт байгуулсан байна. Тодруулбал, Ш.Алтантуяагийн амийг бүрэлгэсэн хэрэгт буруутгагддаг Нажиб Разацын нам ялагдаж, экс Ерөнхий сайд Махатир Мохамадын нам ялжээ.

2006 оны аравдугаар сард Шах Аламын ойролцоох ойд Монгол Улсын иргэн Ш.Алтантуяаг хөнөөсөн бөгөөд 2015 онд Холбооны дээд шүүхээс Азила болон Сирулыг тус хэрэгт буруутай хэмээн цаазын ял оноосон билээ. Гэвч Сирул ялын тогтоол гарахаас өмнө Австрали руу оргон зайлсан бөгөөд Австралийн хууль сахиулагчдад баригдан, Сидней дэх Виллаүүдийн Цагаачлалын саатуулах төвд хоригдсоор байгаа аж.

Улаанбаатарт:



Өнөөдөр
Өдөр 21
Шөнө 0



Маргааш
Өдөр 23
Шөнө 6

ӨДРИЙН ЗУРХАЙ



ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ
САРЫН ШИННИЙН 26.
НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ
ХАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Жаргал үргэлжид ирнэ.

Наран ургах, шингэх:

05.22-20.17



Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гүйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

ӨДРИЙН ХҮН

ЯСНЫ БӨХ

Н.ПУНЦАГБОЛД

Жүдо бөхийн дэлхийн чансаа шинэчлэгдэж, М.Уранцэцэг, Д.Сумъяа нар жиндээ нэгдүгээрт бичигдсэн хэвээр байна. Тэгвэл өөр нэг бөх дэлхийн чансааг тэргүүлж, ясны тамирчин гэдгээ харуулж байгаа нь Г.Мандахнаран. Риогийн олимпын наадамд 65 кг-д барилдаж, хүрэл медалийн оосроос атгаад алдсан тэрбээр жин өгсч барилдаж байгаа. Энэ жилийн улсын аваргад 74 кг-ын жинд барилдаж, түрүүлсэн. Дөрвөн өөр жинд барилдахдаа улсын аваргад долоон удаа түрүүлсэн ховорхон амжилтыг тэр л гаргаж чадсан. Энэ онд 74 кг-д Азийн аваргад түрүүлсэн. Түүний амжилттай оролцсон тэмцээнүүдийг дурьдаад байвал олон. Тиймдээ ч дэлхийн чансааг тэргүүлсэн хэвээр үлдэж, ямархуу эрэмбэтэй бөх гэдгээ харууллаа. Г.Мандахнаран 74, АНУ-ын Ник Гвяздовски 125 кг-д



дэлхийн чансааг өнгөлж байгаа. Харин бусад бүх жинд Оросын бөхчүүд дэлхийн чансааг тэргүүлж байна. Оросын эрэгтэй чөлөөтийнхөн ийн бүх жинд эзэгнэж байхад Монголын бөх дунд нь нэрээ багтааж, дэлхийн чансааг тэргүүлнэ гэдэг том нэр хүнд. Г.Мандахнаранд 2020 оны олимпын наадамд оролцох ч нөөц бололцоо байгаа. Энэ жил болон дараа онд дэлхийн аваргад амжилттай оролцож чадвал бүр ч өөрийгөө батлах учиртай. 2013, 2014 онд дараалж ДАШТ-ээс хүрэл медаль хүртэж байсан амжилтаа ахиулах том зорилго түүнд байгаа нь ойлгомжтой. Улмаар Риод луйвардуулж алдсан медалиа ч Токниогийн олимпоос авах бүр ч том зорилгыг өвөртөлж яваа нь мэдээж. 32 нас гэдэг тамирчны хувьд тийм ч залуу үе биш. Харин Г.Мандахнаран ясны бөх гэдгээ харуулж, дэлхийн чансааг тэргүүлж явна. Тэр яах аргагүй төрмөл тамирчин юм.

TIME OUT

ЗОВЛОНГИЙН УГТАЙ ЕРТӨНЦӨД ХОЁУЛАА АМЬДАРЧ БАЙНА, ХАНЬ МИНЬ

Б.БУНДХОРОЛ

Үлдэх юм ховор шүү дээ хань минь. Үхээд л өгнө дөө цаг нь болохоор хоёулаа. Өнөөдрийн өрдөж авсан зүйл эвдрээд дуусна. Үнэ цэнэтэй хэмээн хайрласан болгон үгүй болно. Цаг нь ирэхээр үр хүүхэд хүртэл чи бид хоёрыг орхиод явна. Цагтаа хэрхэн хайрласныг маань хүртэл тэд мартана. Яг л аав ээжийнхээ ачийг бидэн хоёр мартсан шиг, бас хариулж чадаагүй шиг, ял нь, зэм нь, гэм нь, үр нь болоод тэд бидэнд ойлгуулна.

Хоёулаа хайрлаж явсан юм бүхэн хуурмаг гэдгийг ойлгоно. Хань хамаатан, амраг садан, анд нөхөр мөнх биш гэдгийг удахгүй мэднэ. Өнөөдөр алга ташин магтан сайшаавч, өөрийнх нь эрх ашиг үл ялиг зөрчигдөхөд өшрөхөөд тэд муу хэлэх болно.

Бие, эрхтэн биднийх биш гэдгийг эртхэн мэдвэл хорогдох юмгүй хорвоог орхино, амар. Сэтгэл санаа хангалуун байвал жаргал юм гэдгийг хурдан ухаарвал өлзий болно, бидэнд. Өнөөгийн өр шир бүү хэл өнөө бидний амьдардаг дэлхий хүртэл мөнх

бишийг эртхэн ухаарвал хялбар. Аялаад, дуулаад уярч өгдөггүй араатан шиг аялыг нь олох гэсэн ч олж болдоггүй хорвоо шүү дээ, хань минь. Цаг нь ирэхээр жам нь болохоор мянган бурхан хүрээлсэн ч үхэл ирэх болно. Заяа төөрөг, ус уух хоног нь дуусаагүй бол түмэн чөтгөр, төдий дайны шулам тойрсон ч мэнд амьдарна, хонгор минь. Хувь нь байгаад, тарьсан үр нь бий бол жаргалын шалтгаан зохицдоно. Харин үгүй бол зовлонгийн угтай ертөнцөд зовсоор дуусна шүү дээ, гэргий минь.



twitter



Б.Ганчимэг сэтгүүлч @ganchimeg6163
Гэр бүл салсны гэрчилгээ гээд гэрлэлтийн баталгаанаасаа том шахуу үнэмлэх өгөх юм. Тэрүүтээр яах юм бэ. Манай улсын мөнгө ийм мэтийн эргүү салаагаар их урсдаг юм бна. Салсан хоёр хүн дурсгал болгож далбагар үнэмлэх хадгалах уу... Үнэн инээдтэй юмаа...



г. davaadorj @rdavaadorj
Д.Мөрөн төрийн хариуцлагатай алба хаших ёс зүйн эрх бий юу? С.Зориг агсны гэрийнх нь гадаа хамгаалалтанд зогсож байсан цагдаа: “ Орцонд бол нэг ч хүнийг оруулахгүй, нэг ч хүнийг гаргахгүй байх үүрэгтэй байсан.Гэвч ЦЕГ даргатай (Д.Мөрөн) яриад, олон хүмүүс шууд нэвтрүүлсэн”



Д.Өлзийбаяр @UlziibayarD
Уулын мод ухаж авчирч оршуулахаа Зогсоогоочээ!! Зургийг тогтож сайн хар !! Модны үндэс бүтэн биш тас тас цавчсан. Энэ ургахгүй ! Үхнэ! Хот Дапраа !! @Su_Batbold @UKhurelsukh @ BattulgaKh @tserenbt

facebook.



Мягмаржав Линдо Намуунаа
Өглөө гарахдаа картаа андуурцан байх юм Автобусанд дарсан хүүхэд гэж авдын бич ч одоо юу билээ гээл нам бодоостой
Өнөөдөр төрсөн юм чинь хүүхэд л юмдаа Хаха

ТЭНГИС
КИНО ТЕАТР



ЯЛАГЧ

ПАРАЛЛЕЛЬ ЕРТӨНЦ

РАМПЕЖ

АВЕНГЕРЫ

ГОНЖАМ

ХУАГИААГААН ХУНЖА

Тун Удахив

